

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

"ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ"-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХОА-2025/31-20-ШТА-ГА

Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй, иргэдийн санал аваагүй
төсөл арга хэмжээг төлөвлөснөөр хүрэх үр дүнг тооцох боломжгүй байна

Ховд хот
2025 оны 7 дугаар сар

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.khu@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Мөнхтулга
Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Нарандэлгэр
Цахим хаяг: narandelgera@audit.gov.mn
Аудитор: Ц.Аззаяа
Цахим хаяг: azzayats@audit.gov.mn
Аудитор: Н.Ариунтуяа
Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn
Аудитор: Н.Батзул
Цахим хаяг: batzuln@audit.gov.mn
Аудитор: Н.Батжаргал
Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Монгол Улсын Ерөнхий аудиторовн
2018 оны ... – тушаалын Хавсралт № 02

Гүйцэтгэл, нийцлийн аудитын хураангуй тайлан

Огноо: 2025.07.04
Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ХОА-2025/31-20/НА-ШТА-ГА	Шалгагдсан байгууллага, нэгжийн	Аймаг сумдын ИТХ, ОНХС СТСХ ЗДТГ,
Аудитын нэр:	ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ		
Аудит хийсэн бүтцийн	Гүйцэтгэлийн аудитын баг	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Ахлах аудитор Д.Мөнхтулга, А.Нарандэлгэр Аудитор Н. Батжаргал, Ц. Аззаяа Н. Батзул, Н. Ариунтуяа

Хоёр. Аудитын үр дүн:
2.1 Аудитын зорилго, хамарсан хүрээ:

Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль, журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамрах хүрээ: Аудитад аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, багийн Засаг дарга, аймаг, сумын ОНХС-ийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл,

❖ **БҮЛЭГ 1. САНГИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЖУРАМД ЗААСАН НӨХЦӨЛ, ШАЛГУУРЫГ ХАНГААГҮЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН, ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРИЙГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА**

Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг сумдад холбогдох хууль, журамд заасны дагуу олгосон ч зарим сумууд малын тоо толгойн албан татварыг төлөвлөөгүй байна

1.1.1. Аймгийн ИТХ-аас аймгийн ОНХС-гийн эх үүсвэрийг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу ОНХС-ийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг 27,577.8 сая, өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээний урамшууллаас 1,807.4 сая, өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 5,569.7 сая, малын тоо толгойн албан татвараас 708.8 сая, бусад орлогоос 9,219.1 сая, хандив 6,240.0 сая, нийт 51,122.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

1.1.2. Гүйцэтгэлээр ОНХС-ийн 26,520.0 сая, жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаар 1,807.4 сая, дотоод, гадаадын хандив тусламжаар буюу Хөшөөтийн уул уурхайгаас 7,728.5 сая, өмнөх оны үлдэгдэл, бусад орлогоос 8,029.7 сая, малын тоо толгойн албан татвараас 646.9 сая нийт 44,724.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж 6,398.6 сая төгрөгөөр орлого тасарсан байна.

1.1.3. Энэ нь улсын төсвөөс олгох орлогын шилжүүлэг 1,057.8 сая, урьд оны үлдэгдэл 5,569.7 сая, малын тоо толгойн албан татварын орлого 61.9 сая, бусад орлогыг 1,197.7 сая төгрөгөөр эх үүсвэрийг дутуу бүрдүүлж хандив тусламжийн орлогыг 1,488.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэнтэй холбоотой байна.

1.1.4. Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2¹-д заасны дагуу ОНХС-ийн орлогын шилжүүлгийг сумдад 60 хувиас багагүй байхаар тусгаж байхаар баталсан ч гүйцэтгэлээр аймгийн ОНХС-д 14,979.1 сая төгрөг буюу 57.1 хувь, сумдын ОНХС-д 11,221.7 сая төгрөг буюу 42.9 хувийг хуваарилсан нь "Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн камержуулалт /Хөдөөгийн 16 сум, Жаргалант сумын нийтийн зориулалттай орон сууц/" төсөл арга хэмжээнд 3,864.9 сая төгрөгийг төсөвлөж аймаг худалдан авах ажиллагааг нэгтгэн зарласантай холбоотой байна.

1.1.5. Аймгийн ИТХ-аас ОНХС-д 28,290.7 сая, сумдын ОНХС-д 22,832.1 сая төгрөг баталсны дагуу батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу олгожээ.

1.1.6. Цаашид Сангийн яамнаас нэгдсэн бодлого баримтлан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1²-д заасны дагуу төсвийн хуваарийг эхний саруудад шаардлагатай хэмжээгээр хуваарилж олгох хэрэгцээ байна.

1.1.7. Орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ард иргэдийн оролцоо, засаглалыг сайжруулах зорилготой Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3.5³-д заасны дагуу 2024 онд 12 сумд 1,807.4 сая төгрөгийн урамшуулал олгохоор батлагдсан байна.

1.1.8. Аймгийн 17 сумдаас ОНХС-ийн өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны урамшуулалд Дарви, Эрдэнэбүрэн, Ховд, Цэцэг, Чандмань сумд хамрагдаагүй байгаа нь тухайн ОНХС-гийн удирдлага болох Засаг дарга, нягтлан бодогч нар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

1.1.9. Сумдын ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөлтөд малын тоо толгойн албан татварын орлогыг Төсвийн тухай хуулийн дагуу төлөвлөж байгаа бол Мөст, Цэцэг, Эрдэнэбүрэн сум 2024 оны төсөвт төлөвлөөгүй байна.

¹ энэ хуулийн 59.8-д зааснаас бусад хэсгийн 60 хувийг дараах итгэлцүүрийг харгалзан хуваарилах

² батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах

³ өмнөх жилийн төлөвлөлт, зарцуулалт, үйл ажиллагааны үнэлгээ

1.1.10. Малын тоо толгойн албан татварын орлогыг 708.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 646,9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 61.9 сая төгрөгөөр орлого тасарсан нь Булган сум 60.0, Буянт сум 41.6, Зэрэг сум 13.2, Манхан сум 34.9, Мянгад сум 35.9, Үенч сум 35.6 сая төгрөгөөр орлогоо бүрдүүлээгүйгээс сум, орон нутагт бэлчээрийн менежментийг сайжруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

1.1.11. Иймд сумдын малын тоо толгойн албан татвар, өмнөх оны үлдэгдлээс санхүүжих дүн бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх шаардлагатай байна.

1.1.13 Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5⁴-д заасны дагуу МоЭнКо ХХК-иас аймгийн ОНХС-д 6,000.0 сая, Дарви сум 2,092.1 сая, Цэцэг сум 1,644.6 сая, нийт 9,736.7 сая төгрөгийн орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 11,025.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1,288.6 сая төгрөгийн орлогыг давуулан төвлөрүүлсэн байна.

1.1.14 Алтай сумын ИТХ нь тухайн суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжээс 240.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталсан ч гүйцэтгэлээр орлого бүрдүүлээгүй байна.

Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжийн шаардлага хангаагүй, иргэдийн санал аваагүй, зураг төсөвгүй төсөл арга хэмжээг баталдаг зөрчил буурахгүй байна

1.2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 67,663.1 сая төгрөгийн 1,546 төсөл арга хэмжээнд санал авснаас цахимаар 2,235, цаасаар 17,868, бүлгийн ярилцлагаар 24,134 нийт давхардсан тоогоор 44,237 иргэнээс санал авсан байна.

1.2.2 Иргэдийн саналыг эрэмбэлэн 51,122.8 сая төгрөгийн 948 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталж, 598 төсөл арга хэмжээний 16,510.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээ нь нэн шаардлагатай бус, эдийн засгийн үр өгөөж бага, ТЭЗҮ, зураг төсөвгүй зэрэг шалтгаанаар хасагдсан байна.

1.2.3 Аудитын явцад авсан санал асуулгад 215 иргэн хамрагдаж 61 хувь нь саналаа өгсөнөөс 37 хувь нь саналаа өгөөгүй гэж хариулсан бөгөөд судалгаанд оролцсон иргэдийн тоо хангалтгүй учраас санал асуулгын дүнгээр ОНХС-ийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна.

1.2.4 Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9⁵, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.2⁶, 63.3⁷, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.1.1⁸, 4.1.3⁹-т заасныг үндэслэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймаг, сумд орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулж төлөвлөлтийг хийгээгүй байхад аймаг, сумдын ИТХ-аар баталсан байна. ОНХС-гийн хөрөнгөөр орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хамааралгүй ажлуудыг төлөвлөж баталсан байна.

Аудитын илрүүлэлт

- Цэцэг сум 20.0 сая төгрөгөөр сумын 100 жилийн ойн телевизийн бичлэг хийлгэсэн, ИТХ-ын тоног төхөөрөмжид 20.0 сая, ИТХ-ын даргын өрөөний тохижилтод 7.0 сая, ЭМТ-ийн эмийн өр барагдуулах ажилд 16.0 сая төгрөг,

⁴ тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг

⁵ Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв хамаарна.

⁶ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

⁷ Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.

⁸ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх

⁹ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, төхник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх

- Жаргалант сум нь журамд нийцээгүй Ахмадын баяр, Эмэгтэйчүүдийн баяр, Наурызын баяр, Галдан бошгот хааны мэндэлсний 380 жилийн ойн нээлт зэрэг арга хэмжээнд 29.2 сая төгрөг,
- Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын заалтуудыг мөрдөж ажиллаагүй, иргэдээс авсан саналыг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлээгүй байна.

1.2.5 Аймаг сумдын ОНХС-гийн хөрөнгөөр 2024 онд нийт 948 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсанаас 28 хувь буюу 14,521.1 сая төгрөгийг барилга байгуулж, 24 хувь буюу 12,406.1 сая төгрөгийг их засварт, 24 хувь буюу 12,012.3 сая төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад, аймаг сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт 16 хувь буюу 8,390.1 сая төгрөгийг, ТАХ-нд 8 хувь буюу 3,793.2 сая төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөжээ. Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.1.6¹⁰ дахь заалтыг зөрчин иргэдийн санал аваагүй, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй ажлуудыг жагсаалтад оруулан аймгийн ИТХ-аар батлуулсан байна.

1.2.6 ОНХС-гийн эх үүсвэрийг аймаг, сумдын хөгжлийн хэтийн төлөвлөгөө, бодлогод нийцүүлэн төлөвлөлтийн шаардлага хангасан, иргэдийн саналд нийцүүлэн төлөвлөж хөрөнгө оруулалтын үр өгөөж дээшлүүлэх шаардлагатай байна.

❖ **БҮЛЭГ 2. ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙГ МӨРДӨН АЖИЛЛААГҮЙГЭЭС ХЭРЭГЖҮҮЛСЭН ЗАРИМ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ТООЦООГҮЙ, ЦААШДЫН АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГА БАЙНА**


Төсөвт өртгийг хэсэгчлэн хуваан баталсан, хөрөнгө оруулалтын ажлыг эхлээгүй байхад гүйцэтгэгч нарт санхүүжилт олгосон байна

2.1.1 Аймгийн хэмжээнд 51,122.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 948 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймаг, сумын ИТХ-аар батлуулж үүнээс 20,088.0 сая төгрөгийн 57 төсөл арга хэмжээг нээлттэй тендерээр, 12,727.7 сая төгрөгийн 151 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 813.8 сая төгрөгийн 57 төсөл арга хэмжээг олон нийтийн оролцоотой худалдан авалтаар, 403.8 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг нэг үүсвэрээр худалдан авах аргаар, 2,626.9 сая төгрөгийн 27 төсөл арга хэмжээг онцгой комиссын шийдвэрээр гэрээ шууд байгуулж 10,125.3 сая төгрөгийн 526 төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй худалдан авсан байна.

2.1.2 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.5¹¹ дахь заалтыг зөрчин ижил төстэй арга хэмжээг нээлттэй тендер зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан, ажлын даалгавар болон ажлын тоо хэмжээг өөрчилдөг дутагдал нийтлэг байна.

Аудитын илрүүлэлт

- Цэцэг сум нь худалдан авах ажиллагаа зарлахаас зайлсхийж /Төрийн байгууллагуудын тохижилт, өв соёл уламжлал харуулсан эсгий гэр, гэрийн тохижилт/ төсөл арга хэмжээнд 110.6 сая төгрөг,
- Дарви сум нь Хашаа хийх 47.0 сая төгрөгийн ажлыг тодотголоор батлахдаа 3 төсөл арга хэмжээ болгон хэсэгчлэн хуваасан,
- Алтай сум нь 38.0 сая төгрөгийн төсөвтэй сумын төвд эко 00 нийлүүлэх ажлын худалдан авах ажиллагааны журмыг зөрчин 2 хуваасан,
- Алтай сум нь санхүүгийн чадавч болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг тендерийн баримт бичигт тодорхой заагаагүйгээс тендерт оролцогч нь санхүүгийн чадавч багатай, ижил төстэй ажил гүйцэтгэсэн эсэх нь тодорхойгүй компани шалгаруулсан,
- Жаргалант сум нь үзэсгэлэн худалдаа зохион байгуулах 3*3м хэмжээтэй 30 ширхэг бүт хийлгэх 29.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг төсөвт



¹⁰ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх

¹¹ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно

өртгийг хуваан шууд гэрээ байгуулан худалдан авсан. Үүнд: Шинэ ногооны захын сүүдрэвчний бүтээлээ хийх 10.5 сая, Шинэ ногооны захын төмөр сүүдрэвч рам хийх 18.4 сая,

- Жаргалант сум нь эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх ажилд 35.0 сая төгрөгийн гэрээг Эерэг өөрчлөлт нэмэх нэг ТББ-тай, Танд ойрхон түргэн шуурхай үйлчилгээ, ажилгүйдлийг бууруулах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажилд 25.0 сая төгрөгийн гэрээг Шинэ зууны мэргэд НҮТББ-тай худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр байгуулсан,
- Жаргалант сум нь 3-р цэцэрлэгийн камержуулалт 5.9 сая, 4, 16-р цэцэрлэгийн камержуулалт 17.0 сая болгож төсөвт өртгийг хуваасан,
- Үенч сум нь Хөдөөгийн 4 багт тоног төхөөрөмж худалдан авах 80.0 сая төгрөгийг задалж 4 хуваан гэрээ байгуулсан,
- Аймгийн онцгой комиссын 2024.10.04-ны өдрийн 34 дугаар тогтоолоор 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Магсаржав багийн 62 айл, 72 айл, 52, 2-24 айлын орон сууцны сантехникийн засварын ажлыг шууд гэрээ байгуулсан зөрчлийг СТА-аар илрүүлж, зөвлөмж өгсөн,
- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламж /Жаргалант сум/ 3-р багц/ 29.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд шууд гэрээ байгуулсан,
- Дарви сум нь Төрийн байгууллагуудын хашаа шинэчлэх ажил төндөр зарлахаас зайлсхийж төсвийг хуваан шууд худалдан авалт хийсэн,
- Үенч сум нь 60 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Иргэдийн оролцоотой хашаажуулах аян" ажлыг багц болгон хувааж 6 иргэнтэй гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн.
- Үенч сум нь ажлын даалгавар тоо хэмжээгүйгээр гэрээ байгуулан Цагдаагийн албан хаагчийн мэдүүлгийн өрөөний тохижилт тоног төхөөрөмж, малын мах сүү шинжлэх РН тодорхойлогч төхөөрөмж худалдан авсан,
- Мөнххайрхан сум нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахдаа ижил төстэй ажлыг нэгтгээгүй, хэсэгчлэн хуваасан нь хууль тогтоомжид нийцээгүй,

2.1.3 Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 100.0 сая төгрөгөөс дээш өртөгтэй ажлуудад төндөрийн баталгаа гаргуулаагүй нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1¹², 14.1.1¹³, 14.1.2¹⁴ дахь заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- **Жаргалант сум:** Орон сууц орчмын тохижилт Домбот хотхоны замын орц гарц 136.0 сая, Орон сууц орчмын тохижилт Их монгол 35, 43, Хатан түнгэл 12, 24 айлын орон сууцны замын орц 212.0 сая, Гэрэлтэй Хот төсөл 184.7 сая, Зам тавих (Алагтолгой баг 2, 3-р гудамжны дунд) 796.3 сая, Тоглоомын талбай, тохижилт, ногоон байгууламж (Буянт баг) 140 сая, Хүүхдийн тоглоомын талбай, тохижилт (Рашаант баг) 204 сая, Магсаржав багийн 62 айл, 72 айл, 52, 2-24 айлын орон сууцны сантехникийн засвар 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлуудад төндөрийн баталгаа шаардаагүй,
- **Алтай сум:** Сумын төвийн стадионы өргөтгөл, засвар тохижилт, Сумын төвийн айл өрх рүү цэвэр бохирын шугам дөхүүлэх нэршилтэй төсөл арга хэмжээнүүд нь 100.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ч мөн төндөрийн баталгаа шаардаагүй,
- **Булган сум:** "Халуун ус, сауны хамт барих", "Сумын цэвэр бохирын системийн өргөтгөл хийх ажил"-д баталгаа шаардаагүй,
- **Үенч сум:** Алтайн оргил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, Сумын төвийн суурьшлын бүсийн айл өрхүүдийн цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх 04кВт-н шугам татах трансформатор суурилуулах /Дээд лагерь/ төсөл арга хэмжээнд баталгаа шаардаагүй,

2.1. 4 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын 4.1¹⁵ дахь заалтыг зөрчин зураг төсөвгүй, зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан байна.

Аудитын илрүүлэлт

- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр Халуун усны барилга /Жаргалант сум, Цамбагараа баг/- батлагдсан зураг төсөвгүй төсөл арга хэмжээг 150.0 сая төгрөгөөр төлөвлөсөн,
- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Жаргалант сум, Тахилт баг/ төсөл арга хэмжээний зураг нь магадлалаар баталгаажаагүй,

¹² Энэ хуульд өөрөөр заагаагүй бол захиалагч дараах тохиолдолд төндөрийн баталгаа ирүүлэхийг төндөр шалгаруулалтын баримт бичигт заана

¹³ багцгүй төндөр шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол

¹⁴ багцтай төндөр шалгаруулалтын тухайн багцын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол

¹⁵ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх

- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Ховд BOX" цогцолбор /хүүхэд, залуучуудын контейнер номын сан/ төсөл арга хэмжээний зураг төсөв нь магадлалаар орж баталгаажуулж байхад төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн,

2.1.5 Аймгийн хэмжээнд тайлант онд 948 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 43,906.7 сая төгрөгийн 837 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ байгуулснаас 35,979.1 сая төгрөгийн 778 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 6,520.4 сая төгрөгийн 59 төсөл арга хэмжээ дутуу, 4,337.3 сая төгрөгийн 111 төсөл арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

2.1.6 Тайлант онд бүрэн хэрэгжсэн 778 төсөл арга хэмжээнээс 43 төсөл арга хэмжээний 482.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

2.1.7 Мөн дутуу хэрэгжсэн 59 төсөл арга хэмжээнд 6,520.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулжээ.

2.1.8 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 2021-2023 онуудад гэрээ байгуулсан ч гэрээний үүргээ биелүүлээгүй 8 аж ахуйн нэгжтэй холбоотой 392.1 сая төгрөгийн авлага данс бүртгэлд тусгасан бол 2024 онд гэрээ байгуулсан ч гэрээнд заасан хугацаандаа хэрэгжүүлээгүй, гэрээний хугацаагаа сунгаж авлагыг нэмэгдүүлсэн байна.

2.1.9 Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8¹⁶-д заасны дагуу Буянт, Эрдэнэбүрэн, Үенч сумууд барьцааны хувь болон чанарын баталгаат хугацааг гэрээндээ тусгаагүй байна.

2.1.10 Засгийн газрын 2023 оны 278 тоот тогтоолын 4.8.4¹⁷-д заасан заалтыг зөрчин дараах төсөл арга хэмжээг санхүүжүүлжээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт

- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Ховд BOX" цогцолбор /хүүхэд, залуучуудын контейнер номын сан/ төсөл арга хэмжээг зурагт үзүүлсэн гүйцэтгэлтэй байхад гүйцэтгэлээс илүү 352.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн,
- Нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламж /Жаргалант сум/ 1-р багц /Сангийн хэрмийн тохижилт/ - эхний санхүүжилт олгохдоо бодит гүйцэтгэлд үндэслээгүй 176.3 сая төгрөгийг олгосон,
- Сүү боловсруулах үйлдвэрийн зураг төсөв /Жаргалант сум/ гэрээг 2025.03.01 хүртэл сунгасан ч хүлээлгэн өгөөгүй,
- Улаан үзүүрийн гүүр /Эрдэнэбүрэн сум, Хонгио баг/ 70 хувийн санхүүжилт болох 102.0 сая төгрөгийг олгосон боловч ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж гэрээт хугацаандаа хүлээлгэн өгөөгүй,
- Хадлангийн талбайн хамгаалалт /Буянт сум/ 70 хувийн санхүүжилт болох 59.8 сая төгрөгийг олгосон боловч ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж гэрээт хугацаандаа хүлээлгэн өгөөгүй,
- Буянт, Үенч, Цэцэг, Эрдэнэбүрэн, Дарви сумууд нь ОНХС-аар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний гэрээ байгуулаад урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэлд үндэслэхгүйгээр олгосон,
- Жаргалант сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа Рашаант багт хүүхдийн тоглоомын талбай хийх төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтэд 116.5 сая төгрөгийг олгосон ч ажлаа гүйцэтгээгүй,
- Үенч сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа Алтайн оргил цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлын багц 2, багц 3 ажилд шалгарсан аж ахуйн нэгжид 56.0 сая төгрөгийг олгосон ч ажлаа гүйцэтгээгүй,



¹⁶ Улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилгаа байгууламжид энэ хуулийн 14.3-т заасан хугацаанд гүйцэтгэгчээс хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн тодорхой хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42.6-д заасны дагуу зохицуулна.

¹⁷ Гүйцэтгэлийн санхүүжилтийг хуулиар батлагдсан төсөвт өртөг, магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан төсөвт багтаан гэрээнд үндэслэн тухайн төсөл, арга хэмжээний зураг төсөл, төсөв, холбогдох норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна

2.1.11 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5¹⁸ дахь заалт, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.3¹⁹, 60.3.6²⁰ дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын 4.2²¹ дахь заалтыг зөрчин хуулиар хориглосон арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

- Үенч сум нь сангийн хөрөнгөөр сонгуультай холбоотой 4.0 сая төгрөгийн самбарыг санхүүжүүлсэн.
- Үенч сум нь сангийн хөрөнгөөр хаврын улирлын баруун бүсийн морины уралдаан, эмэгтэйчүүдийн баяр, наурызын баяр, татвар төлөгчдийн өдрүүд зэрэг үйл ажиллагаанд 14.3 сая төгрөгийг зарцуулсан,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хөтөлбөрөөр аймгийн Засаг даргын захирамжаар 321.4 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны шинжтэй зардлуудыг санхүүжүүлсэн,
- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр Төрийн үйлчилгээг өрх бүрд арга хэмжээнд 17 сум 91 багт 25.4 сая төгрөгийн шатахууны зардал олгосон нь төсөвт байгууллагын урсгал үйл ажиллагааг санхүүжүүлсэн,
- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр улсын аварга тогооч шалгаруулах анхдугаар уралдаанд оролцогчдод дэмжлэг, Эвийн хүч хоршооны 10 жилийн ойн дэмжлэг, ардын хувьсгалын 103 жил Үндэсний их баяр наадмаар үндэсний спортоор амжилт гаргасан бөхчүүд, уяачдад олгох урамшуулал, Үндэсний бөхийн түүхэнд оруулсан гавьяаг алдаршуулах үйл ажиллагаанд 55.9 сая төгрөгийг зарцуулсан,
- Мөнххайрхан сум нь сангийн хөрөнгөөр замын зардал, шатахуун, малын үнэ, багшийн шагналын мөнгө, тэмцээний шагналд 5.4 сая төгрөгийг зарцуулсан,
- Халуун усны барилга /Жаргалант сум, Цамбагараг баг/- батлагдсан зураг төсөвгүй төсөл арга хэмжээг 150.0 сая төгрөгөөр төлөвлөсөн, мөн хууль тогтоомж зөрчин нэмэлт гэрээг 2024 оны 10 сарын 08-ны өдөр 299.9 сая төгрөгөөр байгуулсан,

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрэх үр дүнг нэгтгэж тооцоогүй байна

2.2.1 Аймгийн хэмжээнд 2024 оны ОНХС-ийн хөрөнгөөр бүрэн хэрэгжсэн нийт 35,979.1 сая төгрөгийн 778 төсөл арга хэмжээг хөдөө аж ахуй, агааржуулалт, барилга, усан хангамж, боловсрол, эрүүл мэнд зэрэг иргэдийн болон орон нутгийн хэрэгцээ шаардлагад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлжээ.

2.2.2 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр 2024 онд нийт 103 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээс 95 төсөл арга хэмжээнд 22,426.1 сая төгрөгийг зарцуулжээ.

2.2.3 Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг журамд заасан чиг үүргээр нь ангилбал Эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологид 17 төсөл арга хэмжээнд 7,369.4 сая, дэд бүтцийн 20 төсөл арга хэмжээнд 7,349.6 сая, орчны тохижилт, байгаль орчны чиглэлээр 8 төсөл арга хэмжээнд 1,644.3 сая, ус хангамж, эрүүл ахуйн чиглэлээр 2 төсөл арга хэмжээнд 90.0 сая, Хөгжлийн төлөвлөгөө, ТЭЗҮ хийхэд 3 төсөл арга хэмжээнд 884.0 сая, ажлын байр бий болгох 4 төсөл арга хэмжээнд 970.0 сая, журамд заасан чиг үүрэгт хамаарахгүй Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан 21 төсөл арга хэмжээнд 3,806.9 сая төгрөгийг зарцуулжээ.

2.2.4 Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр 721 төсөл арга хэмжээнд 17,707.0 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнд:

- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологид 186 ажлын 4,298.9 сая
- Дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээнд 179 ажилд 4,595.4 сая

¹⁸ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ

¹⁹ үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал

²⁰ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

²¹ Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр Төсвийн тухай хууль болон энэхүү журмын хориглосон заалтад тусгаадаагүй дараах чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ

- Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалахад 241 ажилд 6,676.2 сая
- Ундны усан хангамж, эрүүл ахуйг сайжруулахад 51 ажилд 1,045.0 сая
- Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв, боловсруулахад 4 ажилд 75.0 сая
- Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэхэд 6 ажилд 81.5 сая
- Ажлын байр бий болгоход 2 ажилд 88.5 сая

2.2.5 Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гудамж талбайд гэрэлтүүлэг тавих, зам засвар, худаг ус, малжуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, нийтийн эзэмшлийн засвар хийгдсэнээр ард иргэдийн ая тухтай, аюулгүй орчинд амьдрах таатай нөхцөл бүрдсэн байна. Тухайлбал:

САЙН ЖИШЭЭ:

- Алтай сум: стадионы засвар нь чанартай хийгдэж ард иргэд ая тухтай орчинд баяр наадам хийх боломжийг бүрдүүлсэн,
- Дөргөн сум: сургуулийн спорт заалны шал болон цонх сольсноор хүүхдүүдийн сурах орчныг сайжруулсан,
- Үенч сумын эрүүл мэндийн төвийн их засварын ажлыг хийснээр иргэд ая тухтай орчинд хэвтэн эмчлүүлэх боломжийг бүрдүүлсэн,
- Булган сумын нэгдсэн эмнэлэгт уян дурангийн тоног төхөөрөмжийг худалдан авснаар иргэд сум орон нутагтаа эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн
- Жаргалант сумын 13 дугаар цэцэрлэгийн их засварыг хэрэгжүүлснээр хүүхэд ая тухтай орчинд сурч боловсрох боломж бүрдсэн байна,
- Дарви сум нь 4 багийн худгийг сэргээн зассанаар малчдын усан хангамжийг сайжруулсан,
- Үенч сум: Майдарын цэцэрлэгт хүрээлэнд худаг гаргаснаар цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийг усны асуудлыг бүрэн шийдэж иргэд чөлөөт цагаа ая тухтай өнгөрөөх нөхцөлийг бүрдүүлсэн,
- Цэцэг сумын ЭМТ-д шүдний кабинетын багаж хэрэгсэл авч өгснөөр сумын иргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжтой болсон,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр "Трансформатор шилжүүлж суурилуулах, дотор цахилгааны шинэчлэлт, ажлын оролцоо /Булган сум, Нарлагхан цэцэрлэг/" төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр цэцэрлэгийн хүүхдүүд аюулгүй орчинд сурч боловсрох боломжийг бүрдүүлсэн,



2.2.6 Аудитын явцад бүрэн хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 34,597.0 сая төгрөгийн 764 төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүндээ хүрсэн, 1,375.6 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээ төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байгаа ч нийт төсөл арга хэмжээний хүрээнд авч үзэхэд дараах зөрчил дутагдал байна.

Аудитын илрүүлэлт

- Халуун усны барилга /Жаргалант сум, Цамбагараг баг/ төсөл арга хэмжээг гүйцэтгэгч байгууллага гэрээт хугацаанд ажлаа хүлээлгэн өгөөгүй, нэмэлт гэрээ байгуулахдаа хууль зөрчин гэрээний үнийг 150.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн байгуулсан нь ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй байна.
- Мянгад сумын сургуулийн хашаа шинэчлэх ажлыг гэрээний хугацаандаа хүлээлгэн өгөөгүй, 4.8 сая төгрөгийн хүү алданги тооцоогүй,
- Алтай сумын сангийн хөрөнгөөр сумын төвд гүний өрмийн худаг шинээр гаргах ажлыг 2023 онд Баянговь-Ус ХХК-тай байгуулж 44.5 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон ч одоог хүртэл хүлээн аваагүй, Урт булаг ХХК-тай 2023 онд "Бэлчээрийн даац тодорхойлох, фото мониторингийн цэг нэмэгдүүлэх, хилийн маргаантай цэгийг тэмдэгжүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах" ажлын гэрээг байгуулж 8.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон ч одоог хүртэл хүлээлгэн өгөөгүй,
- Алтай сумын сангийн хөрөнгөөр 2022 онд "Худалдаа, үйлчилгээний цэг, дэлгүүрийн дэргэд нийтийн эзэмшлийн авто зогсоол хийх" төсөл арга хэмжээг Эх нутгийн уулс ХХК-тай байгуулж 147.0 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон ч ажил бүрэн хийгдээгүй 3 жил өнгөрсөн ч одоог хүртэл хүлээн аваагүй,

- Буянт сумын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Бохир соруулах машин авах ажлын даалгавар 2 удаа өөрчлөгдсөн. Техникийн тодорхойлолтыг гаргаагүй, зах зээлийн үнээс өндөр үнээр нийлүүлэгдсэн, одоог хүртэл ашиглагч байгууллага хүлээн авч данс бүртгэлдээ тусгаагүй,
- Жаргалант сумын сангийн хөрөнгөөр Зам тавих (Алагтолгой баг 2, 3-р гудамжны дунд) ажлыг Мөнгөн цэлмэг ноёд групп гүйцэтгэж байгаа бөгөөд замын зурагт (трасс) 2 айлын хашааны өнцөг орсон байгаа тул тухайн төсөл арга хэмжээ нь бүрэн хэрэгжээгүй,
- Цэцэг сум нь эко нойл хийх ажлыг төлөвлөсөн ч ажлын даалгаврын дагуу хийгдэх боломж байхгүй, дэд бүтцээр хангагдаагүй,



Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгийн цаашид гарах зардлыг тооцоогүйгээс хөрөнгийн хадгалалт, хамгаалалт суларч үр өгөөжийг бууруулж байна

2.3.1 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлийг бодитой хийгээгүй, орон нутгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөөгүй ашиглалтыг зөв зохион байгуулаагүй зэргээс шалтгаалан зарим хөрөнгө оруулалтын ажлууд нь зориулалтын дагуу ашиглагдахгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Дарви сумын ЭМТ-н лабораторийн тоног төхөөрөмж ажлын даалгаварт тусгагдсан гематоген аппарат эвдрэлтэй ирсэн ба ажлын хэсэг хүлээж аваагүй, ашиглагч тал ашиглах боломжгүй,
- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн камержуулалт /Хөдөөгийн 16 сум, Жаргалант сумын нийтийн зориулалтын орон сууц/- Бодь электроникс ХХК ний гүйцэтгэсэн ажлаас 129 ширхэг камер ажиллахгүй эвдэрсэн, сүлжээний утас унжсан, сумдад суурилуулсан дугаар илрүүлэгч камер шөнийн цагаар дугаар танихгүй, царай таних систем хэвийн ажиллахгүй, ухаалаг системийн нийт 150 ширхэг лицензийн 50 хувь нь ажиллахгүй байна.



2.3.2 Ховд аймагт ногоон бүс төслийн хүрээнд 5.4 тэрбум төгрөгийн камержуулалтын ажлыг орон нутгийн хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэн ашиглалтад хүлээн авсан ч бүрэн хүчин чадлаар нь ашиглахгүй байгаа, камерын нэгдсэн төвийн үйл ажиллагаа жигдрээгүй, мэргэжлийн боловсон хүчний хангалт муу, завсар үйлчилгээг тухай бүр хийж чадахгүй байгаа нь хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байгаа тул камерийн төвийн албан хаагчдыг сургаж дадлагажуулах, ашиглалтын зардлыг орон нутгийн төсөвт тусган ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

2.3.3 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын зарим ажлууд нь чанаргүй хийгдсэн, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан ч өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлээгүй, зарим хөрөнгө оруулалтын ажлууд нь баталгаат хугацаандаа эвдэрсэн, цаашид ашиглах байгууллагыг ИТХ-аар хэлэлцүүлэн тодорхой болгоогүйгээс хөрөнгийн үр өгөөжийг бууруулжээ.

Аудитын илрүүлэлт

- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "ерөнхий боловсролын 1-р сургуулийн спорт заалны барилгын их засварын оролцоо /Булган сум/" төсөл арга хэмжээ нь ажлын даалгаварт тусгагдсан арга хэмжээг бүрэн хийгээгүй байна. Дээврийн хуучин хаягдлыг бүрэн цэвэрлээгүйгээс таазнаас үнс унасан байдалтай, цонхны зай завсрын хөөсөн дулаалгыг дутуу хийсэнтэй холбоотойгоор дулааны алдагдал ихтэй,
- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн "Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлын оролцоо /Алтай сум/" төсөл арга хэмжээ нь чанаргүй хийгдсэн байна. Тус ЭМТ-ийн гадна заслын шавардлагаа нь ховхорсон, цонхны тавцан хагарсан, цонхоор дулааны алдагдал ихтэй,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дуут дохио суурилуулах 15.8 сая төгрөгөөр 16 ширхэг тоног төхөөрөмж хүлээн авсан боловч баталгаат хугацаанд эвдэрсэн,



- Эрдэнэбүрэн сумын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Хар ус багийн төвд гэрэлтүүлэг хийсэн ажлын чанарын баталгаат хугацаанд 1 гэрэлтүүлгийн нарны панель салж унасан,
- Жаргалант сумын хөрөнгөөр хэрэгжүүлсэн Орон сууц орчмын тохижилт Их монгол 35, 43, Хатантүнгэл 12, 24 айлын орон сууцны замын орц гарц хийх ажлыг хянан үзэхэд зурагт тусгасан 2 цэцгийн мандал хийгдээгүй, 4 ширхэг сандал алга болсон, тоглоомын талбайн зарим резин тасарч цоорч муудсан, дулааны худгийн 1 таг цөмөрч эвдэрсэн,
- Цэцэг сумын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 50ш гэрэлт самбар хийснээс 22ш нь эвдэрсэн, гудамжны гэрэлтүүлгээс 14 гэрэлтүүлэг нь ажиллахгүй,
- Манхан сумын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Баянгол багийн хашаа татах 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг чанаргүй хийсэн, гэрээний хугацаандаа хүлээлгэн өгөөгүй,
- Хан алтайн дуулал цогцолборын гадна их засварын ажлаас дуусгаагүй замын зогсоолын тэмдэг тэмдэглэгээг хийгээгүй,



2.3.3 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээ, бодлогыг тодорхойлж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3.СУМДЫН ИТХ, ЗАХИАЛАГЧИЙН ТАВИХ ХЯНАЛТЫГ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ, УДИРДЛАГА МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

ОНХС-ийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудаас хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүй байна

3.1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 9.4²²-д заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн ИТХ-ын даргын 2024 оны А/98 дугаартай захирамжаар аймагт 2024 оны улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтын чанар үр дүнд хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийг 14 хүний бүрэлдэхүүнтэй томилон аймгийн төвд хийгдэж байгаа ажлуудад хяналтыг хэрэгжүүлэн ажлын тайлан, хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчлийг төсөл арга хэмжээ бүрээр гарган аймгийн ИТХ-д 8 заалт бүхий санал, дүгнэлтийг хүргүүлсэн байна.

3.1.2 Гэвч ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд Буянт, Зэрэг, Мягад, Цэцэг, Эрдэнэбүрэн сумдын ИТХ-аас хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1.3 Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын албанаас Мөст, Цэцэг, Зэрэг, Алтай, Дарви сумдын ОНХС-ийн 2023-2024 оны зарцуулалтад хийсэн хяналтаар 1,188.6 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 230.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 957.9 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн байна.

3.1.4 Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын 5.3.1²³-дэх хэсэгт захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгт заасны дагуу сумууд төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

3.1.5 Захиалагчаас хэрэгжүүлэх хяналт шалгалтад төсөл, арга хэмжээг бүрэн хамруулаагүй, хяналтыг үр дүнгүй хийснээс ажлын тоо хэмжээ дутуу, үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан, гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэхгүй байгаа нь төсөл арга хэмжээ нь чанаргүй, хөрөнгийн үр ашиг буурах, хөрөнгө оруулалт үр дүнгүй хэрэгжих эрсдэл байна.Тухайлбал:

²² "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина"

²³ Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ;

Аудитын илрүүлэлт

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ӨЭМТ-ийн барилга /Жаргалант сум, Тахилт баг/- төсөл арга хэмжээний гүйцэтгэгч нь ногоон байгууламж хийгээгүй,
- Алтай сумын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Шим-Усны засварын ажлын тоо хэмжээнд заагдсан ажлыг дутуу хийсэн, Халуун усны тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын тоо хэмжээнд заагдсан ажлыг дутуу байхад ажлын хэсэг хүлээн авсан
- Алтай сумын "Хуучин сумын төвд морь барианы талбай тохижуулах" ажлын гэрээг байгуулж Сумын Засаг даргын 2024 оны 9 дүгээр сарын 04-ны өдрийн А/145 захирамжаар томилогдсон ажлын хэсэг хүлээн авсан боловч хийгдсэн ажил нь тодорхойгүй, гэрээнд баталгаат хугацаа заагаагүй, 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зөөврийн зориулалттай морины барианы төхөөрөмжийг баяр наадам дууссаны дараа байгууллагын эд хариуцагч хураан аваагүйгээс хийгдсэн тоног төхөөрөмж хаана байгаа нь тодорхойгүй,
- Буянт сумын Цагдаагийн кобаны засварын ажлыг хүлээн авахдаа ажлын даалгаварт заагдсан хяналтын камер 2 ширхэг хийгдээгүй байхад хүлээн авсан,
- Буянт сумын Халуун усны үсчний өрөө тохижуулах ажлыг хүлээн авсан комиссын актгүй ажлын даалгаварт заагдсан ус халаах бойлуур, цонхны хөшиг, цэвэрлэгээний тоног төхөөрөмж зэргийг хүлээлгэн өгөөгүй,
- Дарви сумын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Цэцэрлэгт хүрээлэн /тоног төхөөрөмж/ нийлүүлэх ажлын ажлын даалгаварт заагдсан тоо хэмжээ дутуу стандарт аюулгүй байдал хангаагүй тоног төхөөрөмж нийлүүлсэн ба ажлын хэсэг бүрэн шалгахгүй хүлээж авсан, /Алсыг харагч 2ш кабин дутуу, Нисдэг сандал 9ш дутуу, далайн дээрэмчин аюулгүй байдал хангаагүй/
- Дарви сумын авлагын эхний болон эцсийн үлдэгдлийг баталгаажуулах, эзэн холбогдогч тодорхойгүй хэдэн онд үүсээд одоог хүртэл ажлаа хүлээлгэн өгөөгүй хэдэн төсөл арга хэмжээ байгаа нь тодорхой бус,
- Мянгад сумын ажил хариуцсан мэргэжилтнүүд он дамжин барагдаагүй өвс тэжээлийн авлага 10.0 сая төгрөг, эзэн холбогдогч нь тодорхойгүй 3.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажил зохион байгуулаагүй хяналт хэрэгжүүлээгүй



3.1.6. 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар ОНХС-тай холбоотой 5,645.5 сая төгрөгийн 59 зөрчил илэрснээс 27.7 сая төгрөгийн 6 төлбөрийн акт бичигдэж 229.8 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж 118.1 сая төгрөгийн 2 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлж 47 заалт бүхий 5,269.9 сая төгрөгийн зөвлөмж бичигдсэн байна.

3.1.7 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил нь өмнөх оноос 4,519.3 сая төгрөг, зөрчлийн тоо нь 33-аар өссөн байгаа нь ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хэрэгжүүлж байгаа сумдын хяналт хангалтгүй байна.

3.1.8 УАГ-ын нэгдсэн удирдамжаар 2024 онд "Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 3,757.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 30.1 сая төгрөгийн 6 алдаа зөрчилд төлбөрийн акт, 1,034.7 сая төгрөгийн 6 алдаа зөрчилд албан шаардлага, 2,693.1 сая төгрөгийн 14 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж 19.9 сая төгрөгийн 1 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

3.1.9 Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлсэн боловч 2024 оны ОНХС-ийн хөрөнгөд хийгдэж буй гүйцэтгэлийн аудитаар дээрх илэрсэн алдаа зөрчил дахин давтан гарсаар байгаа нь хэрэгжилт хангалтгүй байна.

Сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн тайланг журамд заасны дагуу холбогдох албан тушаалтнууд бүрэн гаргаагүй байна

3.2.1 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 9.2, 9.3, 9.9, 9.10, 9.11 дүгээр бүлэгт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг хүргэх, тайланд тусгах мэдээллийг тусгажээ.

3.2.2 Аймгийн БОНХОБТХ нь журмын холбогдох заалтын дагуу аймгийн 17 сумдын ОНХС-ийн тайланг хүлээн авсан байна.

3.2.3 Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга, байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж илэрсэн

зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулсан, арга хэмжээ авсан талаарх баримт материалыг аудитад ирүүлээгүй болно.

3.2.4 Аймаг сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 430 төсөл арга хэмжээний 23,609.1 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусган, 19 төсөл арга хэмжээнээс 436.2 сая төгрөгийн бараа материал бэлтгэсэн байна.

3.2.5 Сангийн хөрөнгөөр бэлтгэсэн 59 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжиж байгаатай холбоотойгоор хөрөнгө болон урсгал зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байна.

Аудитын илрүүлэлт

- Цэцэг сум нь сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 131.0 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна

3.2.6 Аймаг сумдын ИТХ-аас баталсан 948 төсөл арга хэмжээ Удирдлагын мэдээллийн системд бүртгэхээс гүйцэтгэлээр 487 төсөл арга хэмжээний 13,165.6 сая төгрөгийн мэдээлэл бүрэн орсон, 213 төсөл арга хэмжээний 19,319.7 сая төгрөгийн мэдээлэл дутуу орсон, 248 төсөл арга хэмжээний 18,637.4 сая төгрөгийн мэдээллийг оруулаагүй байна.

3.2.7 Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан журмын заасан мэдээллийг бүрэн 10.3.2²⁴, 10.3.3²⁵ дахь заалтуудыг сумдын ОНХС-гийн мэргэжилтэн бүрэн оруулаагүй байхад санхүүжилтийг олгосон байна.

3.2.8. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хянахад аймгийн ОНХС-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

3.2.9 Аймгийн ОНХС, сумдын ОНХС-ийн хувьд 2024 оны санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар ОНХС-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээлбэл зохих мэдээллээ мэдээлсэн байна.

Аудитаар нийт 2,907.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 53.3 сая төгрөгийн 3 алдаа зөрчилд төлбөрийн акт, 1,374.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 18 албан шаардлага хүргүүлж, 15.0 сая төгрөгийн хариуцлага тооцох 1 албан шаардлага, 359.2 сая төгрөгийн 2 асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэх, 1,104.5 сая төгрөгийн 15 зөвлөмж хүргүүллээ.

Дүгнэлт:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ОНХС-гийн орлогыг 16,167.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан ч малын тоо толгойн албан татварыг сумууд харилцан адилгүй баталжээ.
- Төсөвт өртгийг хэсэгчлэн хуваан баталж зураг төсөвгүй, ажлын даалгавраар хөрөнгө оруулалтын ажлуудыг гүйцэтгэснээр төсөл арга хэмжээний хүрэх үр дүнг тооцох боломжгүй болсон байна.
- Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлээгүйгээс төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад орохгүй, гэрээг үндэслэлгүйгээр сунгадаг зөрчил давтагдсаар байна.
- Зарим төсөл арга хэмжээ нь иргэдийн амьдралд бодит хувь нэмрийг оруулсан үр өгөөжтэй ажил болжээ.
- Хөрөнгийн цаашид гарах урсгал зардлыг тооцоохгүй баталж хэрэгжүүлснээр хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад сөргөөр нөлөөлжээ.

²⁴ Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д оруулж, оруулсан мэдээллийн дагуу санхүүжилтийг хийнэ;

²⁵ ОНХС-ийн хуваарилалт, төлөвлөлт болон өмнөх оны хэрэгжилт, тайлан, хяналтын талаарх мэдээллийг ОНХС-ийн УМС-д зохих журмын дагуу оруулаагүй бол тухайн зөрчлийг арилгах хүртэл ОНХС, аймаг, нийслэлийн ОНХС-аас орлогын шилжүүлэг олгохгүй;

- Захиалагчийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлээгүйгээс аудитаар илэрсэн алдаа зөрчил буурахгүй байна.
- УМС-д оруулах мэдээллийг иж бүрэн оруулаагүйгээс иргэдийн үнэн зөв мэдээлэл авах, хяналт хэрэгжүүлэх эрх хязгаарлагдах нөхцөл бий болжээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан аймгийн ЗДТГ-ын СТСХ, БОНХОХБТХ, сумдын ЗДТГ-ын хамт олонд талархал илэрхийлье.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР